

“Есөн шижир инвест ББСБ”
ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 05-р
сарын 19-ны өдрийн 9 тоот
тогтоолын хавсралт-10.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийн зорилго нь “Есөн Шижир Инвест” ББСБ /цаашид “ББСБ” гэх/-ийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. ББСБ нь “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрэхийг зорьж ажиллана. Үүнд:

- 1.2.1. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээлэлээр цаг хугацаанд нь хангана;
- 1.2.2. Том болон жижиг хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хүндэтгэх, харилцан итгэлцлийг нэмэгдүүлнэ;
- 1.2.3. Зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангана;
- 1.2.4. Компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулна.

1.3. Энэхүү “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр” нь Монгол Улсын хууль тогтоомж, ББСБ-ийн бодлогын баримт бичиг болон дотоод дүрэм, журам, зааварт нийцсэн байна.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ

2.1. Компани нь хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас, хөрөнгө оруулагчийн хувийн цахим хаяг, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэх боломжийг хангасан бүх хэлбэрээр хүргэнэ.

- 2.1.1. ТУЗ-өөр батлагдсан жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
- 2.1.2. Ээлжит болон ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, иж бүрэн хурлын танилцуулга материал;
- 2.1.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон нөхцөл байдалтай холбоотой сайн, муу мэдээллийг тухай бүр хүргэх мэдээллэх;
- 2.1.4. Дотоодын болон хөндлөнгийн шинжээчдийн зах зээлийн судалгаа, дүгнэлт;
- 2.1.5. Дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн тайлан мэдээлэл;
- 2.1.6. Хөндлөнгийн болон дотоод аудитын тайлан, дүгнэлт,
- 2.1.7. Бизнесийн үнэлгээний тайлан,
- 2.1.8. Шаардлагатай бусад мэдээлэл.

2.2. ББСБ нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана. Үүнд:

- 2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;
- 2.2.2. Санал бодлыг хүлээн авах;
- 2.2.3. Мэдээлэл хүргэх, солилцох;
- 2.2.4. Шаардлагатай бусад.

ГУРАВ. БУСАД

- 3.1.ББСБ-ийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.
- 3.2.Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтэд ББСБ-ын ТУЗ-өөс хяналт тавина.
- 3.3.ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтыг “аудитын хороо”-оор гүйцэтгүүлнэ.
- 3.4.Аудитын хороо нь хяналтыг тасралтгүй байх зарчмыг баримтлан гүйцэтгэнэ.
- 3.5.Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор ББСБ-ын ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.